

ДҮРМИЙН ҮНДЭСЛЭЛ БА ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Сүүлийн жилүүдэд төмөр замын тээврийн салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд олноор бий болж, төмөр замын байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо тогтвортой өсөн нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2023 оны байдлаар суурь бүтэц эзэмшигч 4, тээвэрлэгч 4, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 253, дагнасан болон салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч 250 орчим байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа нь төмөр замын суурь бүтэц, объектууд болон хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл, эзэмшил, ашиглалт ба засвар, техникийн үйлчилгээ болон төмөр замын тээврийн үйлчилгээ, тэдгээрт тавих шаардлагыг тодорхой болгох замаар хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн найдвартай, аюулгүй үйлчилгээг зах зээлд нийлүүлэх шаардлагыг зүй ёсоор бий болгож байна.

“Төмөр замын тээврийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад дээр дурдсан болон бусад нөхцөл байдлуудыг харгалзан, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”, “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн “Төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” зөвлөмж болон бусад хууль тогтоомжийн хүрээнд төмөр замын тээвэрт баримтлах дараах 3 зарчмыг тогтоон баталсан. Үүнд:

1. хөдөлгөөний нэгдсэн зохицуулалттай, тээврийн бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулсан байх;
2. үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангасан, тогтвортой байх;
3. зах зээлийн өрсөлдөөнт нөхцөлийг бий болгож, тэгш оролцоог хангасан байх.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад төмөр замын зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлтэд хамаарах дараах зохицуулалт ба шаардлагууд тусгагдсан. Үүнд:

- ✓ Гуравдугаар бүлэг. 11 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн дүрэм, журам.
 - 11.1. Төмөр замын тээврийн салбарт дараах дүрэм, журам, аргачлал, нормыг баталж мөрдүүлнэ:
 - 11.1.3. төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм;
 - 11.2. Энэ хуулийн ... 11.1.3-т заасан дүрэм ... -ыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ... батална.
- ✓ Тавдугаар бүлэг. 20 дугаар зүйл. Төмөр замын сүлжээ.
 - 20.2.2. зорчигч, ачаа тээвэрлэлтийн нэгдсэн бичиг баримттай байх;
 - 20.2.3. цахим мэдээлэл солилцох нэгдмэл технологи, сүлжээтэй байх.
- ✓ 25 дугаар зүйл. Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ.
- ✓ 25.1. Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:
 - 25.1.3. хөдлөх бүрэлдэхүүнд зэхэлт /эрчим хүч, түлш, шатахуун, ус, хийгээр хангах/ хийх;
- ✓ Зургаадугаар бүлэг. 33 дугаар зүйл. Төмөр замын тээвэрлэлтийн төрөл.
 - 33.1. Төмөр замын тээвэрлэлт дараах төрөлтэй байна:
 - 33.1.1. зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлт;
 - 33.2. Төмөр замаар зорчигч тээвэрлэх харилцааг энэ хуулийн 11.1.3-т заасан ... дүрмээр ... зохицуулна.
- ✓ 34 дүгээр зүйл. Тээвэрлэгчид тавих шаардлага.
 - 34.1. Тээвэрлэгч нь дараах шаардлагыг хангасан байна:
 - 34.1.1. төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх;
 - 34.1.2. зүтгүүртэй байх;
 - 34.1.3. вагонтой байх;
 - 34.1.4. салбар замтай байх;

- 34.1.5. засвар, үйлчилгээний газартай байх.
- 34.2. Тээвэрлэгч нь энэ хуулийн 34.1.2, 34.1.4, 34.1.5-д заасныг түрээсийн, эсхүл ашиглалтын гэрээгээр хэрэгжүүлж болно.
- 34.3. Тээвэрлэгч нь гэрээний дагуу суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн ашиглах, тээвэрлэлтийг зохион байгуулах эрхтэй.
- 34.4. Тээвэрлэгч нь энэ хуулийн 26.1.3-т заасан суурь бүтцийн үйлчилгээний гэрээ байгуулах, хөдлөх бүрэлдэхүүний техникийн болон ашиглалтын аюулгүй байдлыг хангах, шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгохгүй байх үүрэг хүлээнэ.
- 34.5. Тээвэрлэгч нь төмөр замын ачаа эргэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх дунд хугацааны төлөвлөгөөтэй байна.
- 34.6. Тээвэрлэгч нь өөрийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний стандарт, тохирлын үнэлгээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих эрх бүхий нэгжтэй байна.
- 34.7. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн явцад ачаа илгээгч, хүлээн авагчийн зөвшөөрөлгүй хаяг солихыг хориглоно.
- 34.8. Тээвэрлэгч нь энэ хууль болон төмөр замын тээврийн дүрэм, журам, зааварт зааснаас бусад үндэслэлээр үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно.
- 34.9. Тээвэрлэгч нь ачаа илгээгч, ачаа хүлээн авагч хүн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшлийн вагоныг зөвшөөрөлгүй тээвэрлэлтэд ашиглахыг хориглоно.
- ✓ 35 дугаар зүйл. Тээвэрлэлтийн явцад үүссэн хохирол барагдуулах
 - 35.1. Төмөр замын тээвэрлэлтийн явцад үүссэн хохирол барагдуулах, түүнтэй холбоотой маргааныг Иргэний хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам болон гэрээгээр зохицуулна.
- ✓ 36 дугаар зүйл. Тээврийн акт тогтоох
 - 36.4. Тээвэрлэгч дараах нөхцөлд ачаа, тээш, ачаан тээшинд тээврийн акт тогтооно:
 - 36.4.1. тээвэрлэлтийн бичиг баримтад заасан жин, байрны тоо, нэр зөрсөн;
 - 36.4.2. ачаа, тээш, ачаан тээш гэмтсэн, муудсан, үрэгдсэн;
 - 36.4.3. бичиг баримтгүй ачаа, тээш, ачаан тээш илэрсэн;
 - 36.4.4. ачаа, тээш, ачаан тээшгүй тээвэрлэлтийн бичиг баримт илэрсэн;
 - 36.4.5. хулгайлагдсан, дутсан ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэгчид буцаан өгсөн;
 - 36.4.6. хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгээс ачаа олгох бичиг баримт үйлдсэнээс хойш 24 цагийн дотор тээвэрлэгч ачааг буулгалтын замд тавиагүй тохиолдолд ачаа хүлээн авагчийн шаардлагаар.
- ✓ 38 дугаар зүйл. Аюултай ачааны тээвэрлэлт
 - 38.4. Зорчигч галт тэргэнд аюултай ачаа биедээ авч явахыг хориглоно.
- ✓ Наймдугаар бүлэг. 42 дугаар зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах
 - 42.1. Төмөр замын тээврийн аюулгүй байдал нь төмөр замын тээврийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, зорчигч аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, ачаа, тээш, ачаан тээшийг бүрэн бүтэн тээвэрлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.
 - 42.5. Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.
 - 42.6. Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулна:
 - 42.6.1. зорчигч аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;
 - 42.6.2. галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;
 - 42.6.3. ачаа, тээш, ачаан тээшийг аюулгүй, бүрэн бүтэн тээвэрлэх;
 - 42.6.4. төмөр замын тээврийн байгууллагын ажилтны аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
 - 42.6.5. хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр ажиллах.

- 42.7. Төмөр замын суурь бүтцийг эрчим хүчээр тасалдалгүй хангах онцгой объект гэж үзнэ.
- ✓ Есдүгээр бүлэг. 44 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн тариф
 - 44.3. Тээврийн тарифын өөрчлөлтийг мөрдөж эхлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.
 - 44.4. Төмөр замын тээврийн байгууллага нь тээврийн тарифыг цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр мөрдөхийг хориглоно.

Ажлын хэсэг нь “Зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм”-ийн төслийг боловсруулахдаа хуульд заасан дээрх зарчим, зохицуулалт ба шаардлагуудыг үндэслэсэн бөгөөд, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Зорчигчийн вагон депо ба Зорчигч тээврийн төвөөс хийгдсэн “Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, сэтгэл ханамжийн судалгаа”-ны үр дүнг авч үзсэн.

Энэхүү дүрэм нь 5 зүйлтэй. Нэгдүгээр зүйлд дүрмийн зорилго ба зохицуулах харилцааг, хоёрдугаар зүйлд нэр томьёо ба тайлбарыг тусгасан бол гуравдугаар зүйлд мэдээлэл, харилцаа холбоо ба нэгдмэл ажиллагааг хэрхэн зохион байгуулж хангуулах асуудлыг, дөрөвдүгээр зүйлд зорчигч тээвэрлэлтэд, тавдугаар зүйлд тээш, ачаан тээш тээвэрлэлтэд хамаарах нөхцөл, шаардлага ба зохицуулалтуудыг тус тус тусгасан болно.

--oOo--

“ТӨМӨР ЗАМААР ЗОРЧИГЧ, ТЭЭШ, АЧААН ТЭЭШ ТЭЭВЭРЛЭХ ДҮРЭМ”-ИЙН ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ТӨСӨЛ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэ дүрмийн зорилго нь төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх үйл ажиллагааны уялдаа холбоо, зах зээлийн өрсөлдөөнт нөхцөл, тэгш оролцоог хангах, тээвэрлэгч ба хэрэглэгч хоорондын харилцааг тодорхой болгох замаар үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй ба тогтвортой байдлыг хангахад оршино.

1.2. Энэ дүрмээр төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх ерөнхий нөхцөл, шаардлага, хэм хэмжээг тогтоож, оролцогч талуудыг мэдээллээр хангах, солилцох, тээвэрлэлтийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангахтай холбогдолтой харилцааг зохицуулна.

2. НЭР ТОМЬЁО ба ТАЙЛБАР

2.1. Энэ дүрэмд Төмөр замын тээврийн тухай Монгол Улсын хуульд заасан нэр томьёог хэрэглэхээс гадна доор дурдсан нэр томьёог дараах утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:

2.1.1. **байршил** – зорчигчийн эзэмших суудал эсхүл ор;

2.1.2. **гар тээш** – зорчигч биедээ авч явах, энэ дүрмээр зөвшөөрсөн буюу хориглоогүй эд зүйлс;

2.1.3. **зорчих тасалбар** – зорчигчийн галт тэргээр зорчих эрхийг баримтжуулсан мэдээлэл буюу тээвэрлэгч ба зорчигчийн хооронд зорчигч тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох баримт;

2.1.4. **тээшийн тасалбар** – зорчигч эсхүл илгээгч нь тээвэрлэгчтэй тээш, ачаан тээш тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох баримт;

2.1.5. **оролцогч тал** – тээвэрлэлт, мэдээлэл солилцоо, хяналт, удирдлагын болон гүйцэтгэлийн үйл ажиллагаанд оролцож буй хүн, хуулийн этгээд;

2.1.6. **үнэ зарлах** – зорчигч, илгээгч нь сайн дурын үндсэн дээр өөрийн тээш, ачаан тээшийн үнийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн үнэлж, хохирол учирсан нөхцөлд тухайн үнэлгээний дүнгээр тооцож хохирлыг барагдуулах болзолтойгоор нэмэгдэл төлбөрийг төлөх ажиллагаа;

2.1.7. **хэрэглэгч** – зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлт болон дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээг авч буй хүн, хуулийн этгээд;

3. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО ба НЭГДМЭЛ АЖИЛЛАГАА

3.1. Хэрэглэгчийг мэдээллээр хангах

3.1.1. Төмөр замын тээврийн байгууллага нь зорчих тасалбар борлуулалтын бүх хэлбэр ба сувгуудаар, түүнчлэн зорчигчийн галт тэрэг, вагонд доор дурдсан мэдээллийг байршуулан хэрэглэгчид мэдээлнэ:

3.1.1.1. “MNS 5876:2023. Төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ. Зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээний ерөнхий шаардлага” стандартаар тогтоосон зорчигчийн вагоны ба үйлчилгээний ангилал, зэрэглэл. Үүнд:

а) Зорчигчийн вагоны зэрэглэл:

а. Дээд зэрэглэл буюу “тусгай вагон” – тусгай үйлчилгээний, тусгай зориулалтын болон албан хэрэгцээний (цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлтэй);

б. Тохилог зэрэглэл буюу “зөөлөн вагон” – зорчигчийн тасалгаануудтай, нэг тасалгаанд 2 зорчигч хүлээн авах (цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлтэй);

- с. 1-р зэрэглэл буюу “тасалгаат вагон” – зорчигчийн тасалгаануудтай, нэг тасалгаанд 4 зорчигч хүлээн авах (цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлтэй);
 - d. 2-р зэрэглэл буюу “унтлагын вагон” – зорчигчийн нээлттэй таславчуудтай (цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлтэй);
 - e. 3-р зэрэглэл буюу “нийтийн вагон” – зорчигчийн нээлттэй таславчуудтай, суугаа аялах;
 - f. Моторт вагон – хөдөлгүүр бүхий зорчигчийн вагон.
- б) Зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээний ангилал:
- a. Үндсэн үйлчилгээ – зорчигч тээврийн байгууллагаас тогтоосон суурь үйлчилгээ;
 - b. Нэмэлт үйлчилгээ – зорчигч тээврийн байгууллагаас тогтоосон бусад үйлчилгээ;
 - c. Тусгай үйлчилгээ – төмөр замын байгууллагаас тогтоосон тусгай үйлчилгээ;
 - d. Тансаг үйлчилгээ – хэрэглэгчийн захиалгын дагуу үзүүлэх “Premium” үйлчилгээ.
- 3.1.1.2. Гар тээшийн зөвшөөрөгдөх овор, жин. Үүнд:
- a) Гар тээшийн овор: 40x60x80 см-с ихгүй;
 - b) Гар тээшийн жин: 36кг-с ихгүй.
- 3.1.1.3. Зорчигчийн вагоноор тээвэрлэхийг хориглох эд зүйлс. Үүнд:
- a) Зэвсгийн чанартай эд зүйлс;
 - b) Галын аюултай, өөрөө шатах, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт болон хорт бодис, эд зүйлс;
 - в) Түүхий мах, мал амьтны гаралтай түүхий эд;
 - г) Хууль тогтоомжоор биедээ авч явахыг хориглосон бусад эд зүйлс.
- 3.1.1.4. Тариф, хөнгөлөлт, цагийн хуваарийн мэдээлэл. Үүнд:
- a) Галт тэрэгний аяллын цагийн хуваарь;
 - b) Тээш, ачаан тээш хүлээн авах, олгох цагийн хуваарь;
 - в) Зорчих тасалбарын үнэ, тариф, буцаалт, дахин хэвлэлт хийх нөхцөл;
 - г) Хүүхдийн хөнгөлөлт;
 - д) Хөгжлийн ба тулгуур эрхтэний бэрхшээлтэй зорчигчийн хөнгөлөлт;

3.1.2. Төмөр замын тээврийн байгууллага нь доор дурдсан мэдээллийг мэдээлэл харилцааны зохимжит хэлбэрийг сонгон хэрэглэгчид мэдээлнэ:

3.1.2.1. Захиалгын дагуу өөрийн эзэмшлийн зорчигчийн вагоноор хэрэглэгчдэд үйлчлэх;

3.1.2.2. Өөрийн эзэмшлийн вагоныг хүн, хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах;

3.2. Мэдээлэл солилцоо ба нэгдмэл ажиллагаа

3.2.1. Удирдлага, зохион байгуулалт

3.2.1.1. Төмөр замын тээврийн байгууллагууд, тээвэрлэгч, төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч ба хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нарын нэгдмэл үйл ажиллагааг Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Төмөр замын тээврийн тухай Монгол Улсын хуульд заасан чиг үүргийн хүрээнд хариуцан удирдан зохион байгуулж хангуулна.

3.2.1.2. Төмөр замын тээврийн байгууллагууд, тээвэрлэгч, төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч ба хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нар нь дээрх хуульд заасан эрх үүргийн хүрээнд энэ дүрэмд заасан нэгдмэл ажиллагааг хангаж ажиллана.

3.2.1.3. Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллагууд, тээвэрлэгч, төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч ба хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нар нь зорчигчийн галт тэрэг, вагоны болон зорчигчийн ба тээш, ачаан тээшийн мэдээллийг төмөр замын тээврийн мэдээлэл бүртгэх, солилцох журмын дагуу харилцан солилцож ажиллана.

4. ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

4.1. Зорчигч тээвэрлэлтийн ерөнхий нөхцөл

4.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх асуудлыг төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

4.1.2. Монгол Улсаас гадаад улс орнууд руу төмөр замаар зорчигч тээвэрлэх асуудлыг төмөр замын хамтын ажиллагааны байгууллагуудын зорчигч тээврийн хэлэлцээрээр зохицуулна.

4.2. Зорчих тасалбар ба худалдаалалт

4.2.1. Зорчигч тээвэрлэлтийн гэрээ

4.2.1.1. Зорчих тасалбар нь зорчигч ба тээвэрлэгчийн хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох баримт бичиг бөгөөд гэрээлэгч талууд энэ зүйлд заасан эрх ба үүргийг хэрэгжүүлнэ.

4.2.1.2. Зорчих тасалбар нь тухайн зорчигчийн суух ба хүрэх өртөөний нэр, галт тэрэгний дугаар, вагоны дугаар ба зэрэглэл, байршлын дугаар, аялал эхлэхогноо, цаг, минут, олгосон огноо, цаг минут, хүрэх өртөөнд очих огноо, цаг, минут, төлсөн төлбөрийн хэмжээ, зорчигчийг таних өгөгдөл, гэрээний болзол нөхцөл, зорчигчид өгөх санамжийг тус тус агуулна.

4.2.1.3. Зорчих тасалбар нь хүрэх өртөөнд очих огноо, цаг, минут хүртэл зөвхөн тухайн галт тэргэнд хүчинтэй байна.

4.2.1.4. Тээвэрлэгч нь Төмөр замын тээврийн тухай хуульд заасан хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигчийн ба төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүргээс гадна доор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а) зорчигчийг аюулгүй, ая тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, энэ дүрэм болон холбогдох стандартад заасан шаардлага, хэм хэмжээг чанд баримтлан үйлчлэх;
- б) зорчигчийг зорчих тасалбарт заагдсан байршлаар хангах, хүрэх өртөөнд цаг хугацаанд нь хүргэх;
- в) Таваас арван хоёр насны болон энэ зүйлд заасан зорчигчийн эрхээс давсан тооны 5 хүртэлх насны хүүхдэд үйлчлэх хөнгөлөлттэй тарифыг баталж мөрдөх;
- г) гамшиг, онцгой нөхцөл байдал үүссэн болон онц байдал зарласнаас бусад тохиолдолд тээвэрлэлтийн шалтгааны улмаас зорчигчид хохирол учруулсан бол холбогдох баримтыг үндэслэн хохирлыг төлж барагдуулах;
- д) согтуурсан, мансуурсан болон Зөрчлийн тухай Монгол Улсын хуульд заасан бусад байдлаар нийтийн хэв журам, аюулгүй байдалд хамаарах зөрчил гаргасан бол тээвэрлэхээс татгалзах;
- е) зорчигчийн тасалбарыг биеийн байцаалттай тулган шалгаж гэрээлэгч тал мөн эсэхийг тогтоох, зөрүүтэй тохиолдолд тасалбаржуулах буюу гэрээ байгуулах эсхүл үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

4.2.1.5. Зорчигч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а) зөвхөн өөрийн зорчих тасалбараар үйлчлүүлэх, уг тасалбар нь өөрийн болохыг нотлох;
- б) гар тээшийг энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээнд тохируулан бэлтгэх;
- в) зорчих тасалбарт заасан байршлыг эзэмших, ангилал, зэрэглэлд тохирсон үйлчилгээг авах,
- г) өөрийн зорчих тасалбараар тав хүртэлх насны хоёр хүртэлх тооны хүүхдийг (бичиг баримттай байх) асран хамгаалах үүрэгтэйгээр, бие даасан байршил эзлүүлэхгүйгээр үнэ төлбөргүй авч зорчих;

- д) хөгжлийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй зорчигч нь тэргэнцэр, таяг зэрэг туслах хэрэгслийг, бага насны хүүхдийг асран хамгаалах үүрэгтэйгээр зорчиж буй бол тухайн хүүхдийн тэргийг үнэ төлбөргүй авч явах;
- е) зорчих тасалбарыг энэ дүрэмд заасны дагуу буцаах, аяллын огноо, цаг, вагоны зэрэглэл, үйлчилгээний ангиллыг ахиулах;
- ж) зорчих тасалбарыг цахимаар авсан эсхүл гээж үрэгдүүлсэн бол энэ дүрэмд заасны дагуу хэвлүүлж авах;
- з) зорчих явцдаа тасалбарын үнийн зөрүүг буцаан нэхэмжлэхгүйгээр вагоны зэрэглэл, үйлчилгээний ангилал бууруулах;
- и) хууль тогтоомжид заасан нийтийн хэв журам, аюулгүй байдалд хамаарах хэм хэмжээг сахин биелүүлэх;
- к) холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэнэтийн ослын даатгалд даатгуулах;

4.2.1.6. Гэрээлэгч талууд буюу зорчигч ба тээвэрлэгч нар нь маргааныг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ. Тохиролцоонд эс хүрвэл хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

4.2.2. Зорчих тасалбарын захиалга ба худалдаалалт

4.2.2.1. Зорчих тасалбарын захиалга ба худалдаалалтыг тээвэрлэгчийн зөвшөөрлөөр Зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон хуулийн этгээд буюу “зорчих тасалбар борлуулагч” цахим ба цаасан хэлбэрээр хэрэгжүүлнэ.

4.2.2.2. Зорчих тасалбар нь шууд ба дамжих гэсэн хоёр хэлбэртэй байх бөгөөд зорчих тасалбар борлуулагч нь өөр өөр тээвэрлэгчийн зорчих тасалбарыг хэрэглэгчийн хүсэлтийн дагуу зохимжтой хэлбэрээр төлөвлөн олгодог байна.

4.2.2.3. Зорчих тасалбар борлуулагч нь байршлын захиалгыг тээвэрлэгчээс тогтоосон хугацаа ба төлөвлөлтийн дагуу хийх бөгөөд дуусгавар болгоно.

4.2.2.4. Зорчих тасалбарын худалдаалалтыг орон нутгийн галт тэргэнд 2 сарын өмнөөс, олон улсын харилцааны галт тэргэнд 45 хоногийн өмнөөс тус тус эхлүүлнэ.

4.2.2.5. Орон нутгийн галт тэрэгний зорчих тасалбар худалдаалалтыг тухайн галт тэрэг аялж эхлэхээс цахимаар бол 1 цаг, борлуулалтын кассаар бол 15 минутын өмнө эсхүл тухайн галт тэрэгний зорчих байршил дууссан бол тус тус зогсооно.

4.2.2.6. Зорчих тасалбар борлуулагч нь олон улсын харилцааны галт тэрэгний зорчих тасалбарын худалдаалалтыг холбогдох хэлэлцээр, хууль тогтоомж ба тээвэрлэгчээс тогтоосон хугацаанд зогсооно.

4.2.2.7. Тээвэрлэгч нь галт тэргэнд тасалбаргүй суусан хэрэглэгчтэй аяллын явцад зорчигч тээвэрлэлтийн гэрээ байгуулах буюу зорчих тасалбар олгоно.

4.2.2.8. Тээвэрлэгч нь зорчих тасалбарыг буцаах, аяллын огноо, цаг, вагоны зэрэглэл, үйлчилгээний ангиллыг ахиулах, тасалбар хэвлэж өгөх зохицуулалтыг баталж мөрдөнө.

4.2.2.9. Зорчигч өвчтэй болон хүндэтгэх шалтгааны улмаас хүрэх өртөөнөөс өмнө галт тэрэгнээс буусан нөхцөлд нотлох баримтыг үндэслэн зорчоогүй зайн төлбөрийг буцаан олгоно. Зорчигч өөрийн хүсэлтээр галт тэрэгнээс буусан бол зорчоогүй зайн төлбөрийг буцаан олгохгүй.

4.3. Тээвэрлэлтийн өмнөх ба дараах үйлчилгээ

4.3.1 Төмөр замын тээврийн байгууллага нь өөрийн болон бусад тээвэрлэгчийн зорчигчийн галт тэргийг хүлээн авч явуулдаг бол хэрэглэгчдэд зорчигч тээвэрлэлтийн өмнөх ба дараах үйлчилгээг “MNS 5635. Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Төмөр замын буудал. Ерөнхий шаардлага” стандартад нийцүүлэн үзүүлдэг байна.

4.4. Тээвэрлэлтийн үеийн үйлчилгээ

4.4.1. Тээвэрлэгч нь зорчигчийн галт тэрэгний аяллын туршид тээвэрлэлтийн үеийн үйлчилгээг “MNS 5876. Төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ. Зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээний ерөнхий шаардлага” стандартад нийцүүлэн үзүүлдэг байна.

4.4.2. Тээвэрлэгч нь зорчигчийн галт тэрэг 2 хүртэлх минутын хугацаагаар зогсдог өртөө, зөрлөгт зорчигчийн вагоны ажлын талын хаалгыг зорчигчийн тавцан талаар нээх бөгөөд хэрэглэгч, зорчигчдыг галт тэргэнд суух боломжтой аль ч вагоноор оруулж болно.

4.4.3. Тээвэрлэгч нь аялж буй галт тэргэнд онцгой нөхцөл үүссэн, гэнэтийн шалтгааны улмаас вагон салгагдсан тохиолдолд зорчигчдод үйлчлэх асуудлыг журмаар зохицуулна.

4.5. Өндөр настан, хөгжлийн ба хөдөлгөөний бэрхшээлтэй, асаргаа шаардлагатай зорчигчид үйлчлэх

4.5.1 Тээвэрлэгч нь өндөр настан, хөгжлийн ба хөдөлгөөний бэрхшээлтэй, асаргаа шаардлагатай зорчигч, хэрэглэгчдэд үйлчлэх зохицуулалт, шаардлагыг өөрийн байгууллагын хүчин чадал, нөөц боломжид суурилан тодорхойлж мөрдүүлнэ.

4.6. Зорчигчийн вагоноор амьтан, ургамал тээвэрлэх

4.6.1 Зорчигч нь хууль тогтоомжоор тусгайлан хориглоогүй бол энэ дүрмээр тогтоосон овор хэмжээнээс хэтрээгүй амьтдыг эрх бүхий байгууллагын шинжилгээний дүгнэлттэйгээр доор дурдсан шаардлагад нийцүүлэн зорчигчийн вагоноор тээвэрлэж болно. Үүнд:

- а) үслэг амьтан – тээвэрлэх зориулалттай хайрцаг буюу цүнхэнд
- б) шувуу – тээвэрлэх зориулалтын торонд, бүтээлэгтэйгээр;
- в) усны амьтан – битүүмжилсэн саванд буюу тагийг онгойлгохгүйгээр;
- г) хоёр нутагтан, хэвлээр явагч, шавж, бусад амьтан – тээвэрлэх зориулалттай саванд, аюулгүй байдлыг ханган;

4.6.2 Зорчигч нь хууль тогтоомжоор тусгайлан хориглоогүй бол энэ дүрмээр тогтоосон овор хэмжээнээс хэтрээгүй бол үндэс бүхий тасалгааны ургамлыг вагоныг бохирдуулахгүй байдлаар, суулгац болон модлог ургамлыг дагалдах баримт бичигтэйгээр дээрхийн адил зорчигчийн вагоноор тээвэрлэж болно.

4.6.3 Энэ зүйлд зөвшөөрснөөс бусад амьтан, ургамлыг тээшийн вагоноор тээвэрлэнэ.

5. ТЭЭШ, АЧААН ТЭЭШИЙН ТЭЭВЭРЛЭЛТ

5.1. Тээш, ачаан тээш тээвэрлэлтийн ерөнхий нөхцөл

5.1.1. Тээвэрлэгч нь тээш, ачаан тээшийг зориулалтын тээшийн вагоноор тээвэрлэнэ.

5.1.2. Тээвэрлэгч нь орон нутгийн дайгуул галт тэргэнд – шаардлагатай тохиолдолд, бусад галт тэргэнд –тус бүрд нь тээшийн вагон аялуулна.

5.1.3. Тээвэрлэгч нь олон улсын харилцааны галт тэргэнд тээшийн вагон аялуулах асуудлыг зорчигч тээврийн хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2. Тээш, ачаан тээш тээвэрлэлтийн гэрээ

5.2.1. Тээш, ачаан тээшийн төлбөрийн баримт нь зорчигч, илгээгч буюу тээвэрлүүлэгч тал болон тээвэрлэгч талуудын хооронд энэ зүйлд заасан болзол, нөхцөлөөр тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох баримт болно.

5.2.2. Тээвэрлэгч нь доор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а) Тээш, ачаан тээш хүлээн авах, олгох цагийн хуваарийг галт тэрэгний аяллын цагийн хуваарьтай уялдуулах

- б) Тээш, ачаан тээшийг зорчигч ба илгээгчээс хүлээн авч төлбөрийн баримт үйлдсэнээс хойш хүлээн авагчид олгох хүртэл тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хангах;
- в) Зорчигчийн галт тэрэгний зогсолттой бүх өртөө, зөрлөгт тээш, ачаан тээшийг хүлээн авах, олгох;
- г) Тээш, ачаан тээшид зориулалтын багаж төхөөрөмжөөр эсхүл гадна үзлэгээр сэжигтэй байдал илэрсэн бол илгээгчийн зөвшөөрлөөр хамтарсан үзлэг хийх, үзлэг хийлгэхээс татгалзсан эсхүл хууль тогтоомжоор хориглосон эд зүйлс илэрсэн, түүнчлэн баглаа боодол, бүрэн бүтэн байдал нь энэ дүрэмд заасан шаардлага хангаагүйболон овор,жин, хадгалалтын горим зэрэг үзүүлэлт нь техникийн боломжоос хэтэрсэн бол хүлээн авахаас татгалзах;
- д) Тээш, ачаан тээшийг Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан горимын дагуу тээвэрлэх;
- е) Тээвэрлэлтийн улмаас тээвэрлүүлэгчид хохирол учруулсан бол гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлж барагдуулах.

5.2.3. Тээвэрлүүлэгч нь доор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а) Тээш, ачаан тээшийг доор дурдсан шаардлагад нийцүүлэн тээвэрлэлтэд бэлдэх:
 - а. тээвэрлэгчийн техникийн боломжийг судалж нийцүүлэх;
 - б. тээвэрлэх явцад тухайн эд зүйлийн бүрэн байдлыг найдвартай хангахуйц байдлаар савлаж болон баглаж бэлтгэх;
 - с. эмзэг ачаанд зохих тэмдгийг наалгах;
 - д. амьтан, ургамал тээвэрлүүлэх бол энэ дүрмийн 4.6-д заасны нэгэн адилаар бэлдэх;
- б) Тээвэрлэлтийн мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэх;
- в) Тээш, ачаан тээшийг сайн дураар даатгуулах эсхүл үнэ зарлах;
- г) Тээвэрлэлтийн төлбөрийг тээвэрлэгчээс тогтоосон тарифын дагуу төлөх;
- д) Тээвэрлэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас тээш, ачаан тээшийн бүрэн бүтэн байдал алдагдсан нөхцөлд даатгуулсан бол даатгалын байгууллагаас, үнэ зарласан бол зарласан үнийн дүнгийн хэмжээгээр, үнэ зарлаагүй бол тээвэрлэгчээс баталсан тарифын дагуу, цаг хугацаа оройтуулсны улмаас материаллаг хохирол учирсан бол нотлох баримтын дагуунөхөн төлбөрийг нэхэмжлэх.

5.2.4. Гэрээлэгч талууд буюу тээвэрлэгч ба тээвэрлүүлэгч нар нь маргааныг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ. Тохиролцоонд эс хүрвэл хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

5.3. Тээвэрлэгч хоорондын харилцаа

Тээвэрлэлтийг хэд хэдэн тээвэрлэгч гүйцэтгэсэн бөгөөд тээвэрлүүлэгчид хохирол учруулсан бол тухайн тээш, ачаан тээшийг анх хүлээн авч гэрээ байгуулсан тээвэрлэгч нь гэрээний үүргийн дагуу тээвэрлүүлэгчид төлж барагдуулах бөгөөд хохирлыг буруутай тээвэрлэгчээс холбогдох гэрээнд заасан болзол журмын дагуу нэхэмжилнэ;

5.4. Тээш, ачаан тээшийг хүлээн авах, хадгалах үйлчилгээ

5.4.1. Тээвэрлэлтэд хүлээн авах тээш, ачаан тээшийн нэг байр ачааны овор, жингийн зохимжтой хэмжээг тээвэрлэгч нарын техникийн боломжид нийцүүлэн Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно. Тогтоосон хэмжээнээс илүү техникийн боломжтой тээвэрлэгч нь тухайн тээш, ачаан тээшийг өөр тээвэрлэгчийн галт тэргэнд шилжүүлэн ачихгүй нөхцөлд өөрийн хүчин чадалд нийцүүлэн тээвэрлэж болно.

5.4.2. Тээвэрлэгч нь тээшийн агуулахыг зохион байгуулахдаа түгээмэл тээвэрлэгддэг, хадгалалтын тусгай нөхцөл шаарддаг тээш, ачаан тээшийг хадгалах боломжийг бүрдүүлсэн байна.

5.4.3. Тээвэрлэгч нь хүлээн авсан тээш, ачаан тээшийн хадгалалтын явцад мэдүүлгийн хуудсанд тусгаагүй түргэн муудах ачаа (мах, сүү, ногоо, жимс г.м.), хагарч эвдрэх хэврэг ачаа (шил, шаазан эдлэл, телевизор г.м.) гэмтсэн байвал уг хохирлыг хариуцахгүй.

5.4.4. Тээш, ачаан тээшийг хадгалсны төлбөрийг хүлээн авснаас илгээх, тээвэрлэн ирсэн өдрөөс хүлээлгэн өгсөн өдөр хүртэлх хугацаагаар тооцож, тогтоосон тарифын дагуу төлүүлнэ.

5.5. Тээш, ачаан тээшийг тээвэрлэх

5.5.1. Тээвэрлэгч нь тээшийг зорчигчийн аялж буй галт тэргээр тээвэрлэнэ.

5.5.2. Дараах ачаан тээшийг эхний ээлжинд тээвэрлэнэ. Үүнд:

- а) сонин, бусад өдөр тутмын тогтмол хэвлэл;
- б) түргэн гэмтэж, муудах бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн;
- в) амьтан, ургамал;
- г) шарил, цогцос.

5.5.3. Тээвэрлэгч нь тээшийн тээвэрлэлтийг зохион байгуулахдаа түгээмэл тээвэрлэгддэг, хадгалалтын тусгай нөхцөл шаарддаг тээш, ачаан тээшийг тээвэрлэх боломжийг бүрдүүлсэн байна.

5.6. Тээш, ачаан тээшийг олгох, сэлгэн ачих

5.6.1. Тээш, ачаан тээшийг төлбөрийн баримтыг үндэслэн олгоно.

5.6.2. Тээвэрлэгч нь тээш, ачаан тээшийг сэлгэн ачих бол дараагийн тээвэрлэгчид албан журмаар хүлээлгэн өгнө.

5.6.3. Сэлгэн ачсан тээш, ачаан тээшийг хүлээн авсан тээвэрлэгч нь түүний бүрэн бүтэн байдлыг хүлээлгэн өгөх хүртэл хариуцах ба тээвэрлүүлэгчид хохирол учруулсан бол хохирлын мөнгөн дүнг гэрээ байгуулсан тээвэрлэгчид шилжүүлж барагдуулна.

--oOo--